# Аудио болон теле хурал хийх журам

1. Хэлэлцэх асуудал

| № | Хэлэлцэх асуудал | Хариуцах мэргэжилтэн | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Оролцогсдын бүртгэл танилцуулга | Дата менежер | 5 минут |
| 2 | Томуугийн харуулдан тандалтын нэгж (ТХТН)-үүдийн мэдээ ирүүлсэн байдал | Дата менежер | 5 минут |
| 3 | ТХТН-ээс ирүүлсэн сорьцонд хийсэн шинжилгээний дүн | ХӨСҮТ, Вирүс судлалын лабораторийн эрхлэгч, вирүс судлагч эмч | 5 минут |
| 4 | Томуу, томуу төст өвчин (ТТӨ), Амьсгалын замын цочмог халдвар (АЗЦХХ)-ын байдал, цаг үеийн мэдээлэл | ТҮН-ийн дарга, халдвар судлагч их эмч | 5 минут |
| 5 | ТҮН болон ТХТН-үүдийн ТТӨ-ий дэгдэлтийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ | ТҮН-ийн дарга, ТХТН-үүд эмч, мэргэжилтэн | 10 минут |
| 6 | ТТӨ, АЗЦХХ-ын эмнэлзүйн онцлог, эмнэлзүйн менежмент | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч мэргэжилтэн | 10 минут |
| 7 | ХӨСҮТ-ийн бусад алба, тасгуудын мэдээлэл | Алба тасгуудын мэргэжилтэн | 10 минут |
| 8 | Асуулт, хариулт, санал солилцох | Бүгд | 5 минут |
| 9 | Дүгнэлт | ТҮН-ийн дарга | 5 минут |

2. Хурлын бэлтгэл ажил
   1. Томуугийн үндэсний нэгж нь хурлын хөтөлбөрийг боловсруулж, хурлыг өмнөхөдөр хуралд оролцох бүх нэгжүүд рүү цахим хэлбэрээр илгээсэн байна.
   2. Хурал эхлэхээс 10 минутын өмнө хуралд оролцох мэргэжилтнүүд цугларсан, хурлын өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байна.

3. Хурлын дэг

   1. Аудио хурлыг “Skype” ашгилан явуулна.
   2. Теле хурлыг теле-конференцийн өрөөг ашиглан явуулна.
   3. ТХТН-үүд хуралдааны өөрийн талын ахлагчийг сонгосон байна.
   4. Хурлын явцад оролцогчид мэдээлэл хийх, асуулт, хариулт өгөхөөс бусад үед микрофоныг mute эсвэл off горимонд байлгана.
   5. ТҮТ-ийн хурал даргалагч ХӨСҮТ, ТҮТ, ЭХЭМҮТ-өөс оролцогч талуудыг танилцуулсны дараа ТХТН-үүдээс оролцогчид хурал даргалагчийн асуусан дараалаар өөрийн болон бусад оролцогчдын нэр, албан тушаалыг танилцуулна.
   6. Дүүргүүдэд ЭМТ, НЭ, аймгуудад ЭМГ, НЭ, БОЭТ, ӨЭМТ-ийн мэргэжилтнүүд нэг газраас холбогдоно.
   7. Мэдээлэл хийх, асуулт асуух, хариулах болон санал хэлэхдээ ярьж буй хүнийг дуустал хүлээгээд, дараа нь өөрийн нэр, албан тушаалаа танилцуулж, товч, тодорхой ярина. Ярьж дуусаад “миний хэлэх зүйл дууслаа”, “асуулт дууслаа” гэж мэдэгдэнэ.
   8. Техникийн шалтгаанаас болж тасалдал гарсан тохиолдолд ТҮТ-ийн дата менежер Б.Ганцоожтой утсаар (утас: 91998239) эргэн холбогдоно.